



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/82/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 125

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 40.6 хувиар өссөн байна.

4525020206

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 76 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 98.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	178,549,879.20	199,363,182.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	98,674,379.20	82,947,392.93
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	98,674,379.20	82,947,392.93
31210	Төгрөг	98,674,379.20	82,947,392.93
31211	Төрийн сангийн харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах	10,000.00	-
33	АВЛАГА	-	297,500.00
33500	Бусад авлага	-	297,500.00
33510	Байгууллагаас авах авлага	-	297,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,875,500.00	116,118,290.00
35400	Хангамжийн материал	79,875,500.00	116,118,290.00
35420	Аж ахуйн материал	18,552,000.00	18,552,000.00
35460	Хүнсний материал	10,689,650.00	4,338,690.00
35470	Бусад хангамжийн материал	50,633,850.00	93,227,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,682,185,886.48	1,656,848,060.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,682,185,886.48	1,656,848,060.66
39200	Биет хөрөнгө	1,668,955,886.48	1,644,104,060.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,714,932,274.00	1,714,932,274.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(146,552,818.20)	(195,446,399.76)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	42,331,466.00	80,357,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,607,576.48)	(18,417,361.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,965,661.05	62,982,067.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,250,196.39)	(28,159,932.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,414,165.00	37,414,165.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,277,088.50)	(9,558,353.06)
39300	Биет бус хөрөнгө	13,230,000.00	12,744,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,230,000.00	12,744,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,860,735,765.68	1,856,211,243.59
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,860,735,765.68	1,856,211,243.59
51	Засгийн газрын хувь оролцоо	1,860,735,765.68	1,856,211,243.59
51100	Засгийн газрын оруулсан капитал	180,498,517.49	180,498,517.49
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	180,498,517.49	180,498,517.49
51200	Хуримтлагдсан үр дүн	1,401,140,244.84	1,396,615,722.75
51210	Өмнөх үеийн үр дүн	1,356,497,940.43	1,418,977,694.84
51220	Тайлант үеийн үр дүн	44,642,304.41	(22,361,972.09)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	279,097,003.35	279,097,003.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,860,735,765.68	1,856,211,243.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	764,164,675.17	1,048,575,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,008,200.00	66,438,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,008,200.00	66,438,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,157,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,157,600.00
120009	Бусад орлого	10,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	26,468,200.00	47,843,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,530,000.00	16,437,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	731,156,475.17	982,137,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	646,606,600.00	847,807,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	646,606,600.00	847,807,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	84,549,875.17	134,329,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	84,549,875.17	134,329,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	719,522,370.76	1,063,018,986.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	719,522,370.76	1,063,018,986.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	714,913,670.76	1,044,855,970.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,893,106.14	694,792,246.91
210101	Үндсэн цалин	313,727,769.14	449,906,039.18
210102	Нэмэгдэл	94,920,962.00	225,591,177.28
210104	Урамшуулал	12,244,375.00	19,295,030.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,883,032.37	87,014,999.64
210201	Тэтгэврийн даатгал	39,064,405.02	59,294,223.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,585,045.53	6,961,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,430,249.28	3,480,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	777,276.64	3,480,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,026,055.90	13,798,576.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,494,775.17	98,043,483.86
210301	Гэрэл, цахилгаан	9,702,741.17	16,124,045.86
210302	Түлш, халаалт	44,298,166.00	62,264,084.00
210303	Цэвэр, бохир ус	18,493,868.00	19,655,354.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,191,800.00	-
210408	Бараа материал акталсны зардал	8,191,800.00	-
2105	Нормативт зардал	58,527,920.00	61,970,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	475,450.00	-
210502	Хоол, хүнс	58,052,470.00	61,970,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,939,100.00	2,745,000.00
210604	Урсгал засвар	4,939,100.00	2,745,000.00
2107	Томилолт, зочны зардал	486,000.00	-
210702	Дотоод албан томилолт	486,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,167,579.00	2,225,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	907,200.00	-

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,260,379.00	2,225,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,330,358.08	98,063,839.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,240,300.00	28,457,199.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	126,400.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,963,658.08	69,606,640.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,608,700.00	18,163,016.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,608,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,608,700.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	18,163,016.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,163,016.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	44,642,304.41	(14,443,786.34)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,918,185.75
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	7,918,185.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	44,642,304.41	(22,361,972.09)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	731,166,475.17	983,997,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,000.00	1,860,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,000.00	1,860,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,860,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,860,100.00
120009	Бусад орлого	10,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	731,156,475.17	982,137,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	646,606,600.00	847,807,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	646,606,600.00	847,807,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	84,549,875.17	134,329,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	84,549,875.17	134,329,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	655,005,592.68	996,444,186.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	655,005,592.68	996,444,186.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	650,396,892.68	978,281,170.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,893,106.14	694,792,246.91
210101	Үндсэн цалин	313,727,769.14	449,906,039.18
210102	Нэмэгдэл	94,920,962.00	225,591,177.28
210104	Урамшуулал	12,244,375.00	19,295,030.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,883,032.37	87,014,999.64
210201	Тэтгэврийн даатгал	39,064,406.92	59,294,223.05
210202	Тэтгэмжийн даатгал	4,585,045.53	6,961,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,430,249.28	3,480,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	777,274.74	3,480,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,026,055.90	13,798,576.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,494,775.17	98,043,483.86
210301	Гэрэл, цахилгаан	9,702,741.17	16,124,045.86
210302	Түлш, халаалт	44,298,166.00	62,264,084.00
210303	Цэвэр, бохир ус	18,493,868.00	19,655,354.00
2105	Нормативт зардал	62,201,150.00	55,619,590.00
210502	Хоол, хүнс	62,201,150.00	55,619,590.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,055,100.00	19,983,100.00
210604	Урсгал засвар	12,055,100.00	19,983,100.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,260,379.00	2,225,850.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,260,379.00	2,225,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,609,350.00	20,601,899.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,355,250.00	17,398,274.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,254,100.00	3,203,625.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,608,700.00	18,163,016.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,608,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,608,700.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	18,163,016.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,163,016.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	76,160,882.49	(12,446,986.27)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,589,700.00	3,270,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,589,700.00	3,270,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,589,700.00	3,270,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,589,700.00	3,270,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,589,700.00)	(3,270,000.00)
VIII	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	74,571,182.49	(15,716,986.27)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,103,196.71	98,674,379.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	98,674,379.20	82,947,392.93

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/тегрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,498,517.49	279,097,003.35	1,356,497,940.43	1,816,093,461.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,498,517.49	279,097,003.35	1,356,497,940.43	1,816,093,461.27
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	44,642,304.41	44,642,304.41
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,498,517.49	279,097,003.35	1,401,140,244.84	1,860,735,765.68
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	180,498,517.49	279,097,003.35	1,401,140,244.84	1,860,735,765.68
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	17,837,450.00	17,837,450.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	180,498,517.49	279,097,003.35	1,418,977,694.84	1,878,573,215.68
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(22,361,972.09)	(22,361,972.09)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	180,498,517.49	279,097,003.35	1,396,615,722.75	1,856,211,243.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	00.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,078,324,000.00	979,701,070.13	(98,622,929.87)	91.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,078,324,000.00	979,701,070.13	(98,622,929.87)	91.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,078,324,000.00	979,701,070.13	(98,622,929.87)	91.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763,036,000.00	694,792,246.91	(68,243,753.09)	91.1
210101	Үндсэн цалин	508,971,500.00	450,921,629.18	(58,049,870.82)	88.6
210102	Нэмэгдэл	246,309,100.00	224,575,587.28	(21,733,512.72)	91.2
210104	Урамшуулал	7,755,400.00	19,295,030.45	11,539,630.45	248.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,704,500.00	87,014,999.64	(2,689,500.36)	97.0
210201	Тэтгэврийн даатгал	61,000,700.00	59,294,223.05	(1,706,476.95)	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	7,174,900.00	6,961,200.00	(213,700.00)	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,588,000.00	3,480,500.00	(107,500.00)	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,588,000.00	3,480,500.00	(107,500.00)	97.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,352,900.00	13,798,576.59	(554,323.41)	96.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,329,500.00	98,043,483.86	(16,286,016.14)	85.8
210301	Гэрэл, цахилгаан	28,800,000.00	16,124,045.86	(12,675,954.14)	56.0
210302	Түлш, халаалт	72,067,600.00	62,264,084.00	(9,803,516.00)	86.4
210303	Цэвэр, бохир ус	13,461,900.00	19,655,354.00	6,193,454.00	146.0
2105	Нормативт зардал	62,134,500.00	55,619,590.00	(6,514,910.00)	89.5
210502	Хоол, хүнс	62,134,500.00	55,619,590.00	(6,514,910.00)	89.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	18,123,000.00	(1,877,000.00)	99.9
210604	Урсгал засвар	20,000,000.00	18,123,000.00	(1,877,000.00)	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,408,300.00	2,225,850.00	(182,450.00)	92.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,408,300.00	2,225,850.00	(182,450.00)	92.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,711,200.00	23,881,899.72	(2,829,300.28)	89.4
210901	Баруун үйлчилгээний бусад зардал	20,235,200.00	17,408,274.72	(2,826,925.28)	86.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,476,000.00	6,473,625.00	(2,375.00)	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,078,324,000.00	963,974,083.86	(114,349,916.14)	94.4
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	847,807,600.00	847,807,600.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	847,807,600.00	847,807,600.00	0.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	134,329,500.00	116,166,483.86	(18,163,016.14)	89.6
132001	Орон нутгийн төсвөөс	134,329,500.00	116,166,483.86	(18,163,016.14)	89.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	96,186,900.00	00.0	(96,186,900.00)	00.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	96,186,900.00	00.0	(96,186,900.00)	00.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	98,674,379.20	98,674,379.20	00.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	82,947,392.93	82,947,392.93	00.0
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.0	00.0	00.0	00.0
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	00.0	100.0
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	28	1	96.6
6	Удирдах ажилтан	1	1		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	17	16	1	94.1
8	Үйлчлэх ажилтан	11	11	00.0	100.0
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	158	126	32	79.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэг нь “Боловсролын шинэ хуулийг өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж, цэцэрлэгийн бодлого, төлөвлөлт, сургалтын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг ахиулж, хүүхдэд ээлтэй зан чанар, харилцааны эерэг хандлагыг эрхэмлэн суралцагч байгууллага болох” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус цэцэрлэг нь Дархан Уул аймгийн Хонгор сумын 2-5 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох боловсролын үйлчилгээг бүрэн хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” ;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноо 4,524.6 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	98,674.4	82,947.4	(15,727.0)
Авллага	-	297.5	297.5
Бараа материал	79,875.5	116,118.3	36,242.8
Үндсэн хөрөнгө	1,682,185.9	1,656,848.0	(25,337.9)
Нийт хөрөнгө	1,860,735.8	1,856,211.2	(4,524.6)
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,860,735.8	1,856,211.2	(4,524.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,860,735.8	1,856,211.2	(4,524.6)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 82,947.4 мянган төгрөг болж өмнөх оноос 15,727.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна. Тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 116,118.3 мянган төгрөг болж 36,242.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 89,740.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 16,437.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, бараа материалын шинж чанар агуулсан 12,003.5 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлэн авч, үндсэн хөрөнгийн шинж агуулсан 1,560.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлж, 77,718.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 25,337.9 мянган төгрөгөөр буурчээ. Тодруулбал тайлант онд төсвийн хөрөнгөөр 3,270.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, бараа материалын данснаас 12,128.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн бүртгэж, Боловсролын ерөнхий газраас 11,493.0 мянган төгрөгийн 6 ширхэг зөөврийн компьютер хүлээн авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар “Боловсролын байгууллагын тоног төхөөрөмж” төслийн хүрээнд 18,000.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэц, автомат аяга таваг угаагч, ногоо хэрчигч, “Шугамын өнгөр зэв үүсэхээс хамгаалах вүлкам төхөөрөмж” төслийн хүрээнд 7,700.0 мянган төгрөгийн 50мм шугам вүлкам, “Багшийн хөгжил ” төслийн хүрээнд 8,650.0 мянган төгрөгийн усны аппарат, сэтгүүлийн ширээ, буйдан, цахилгааны эх үүсвэр, зурагт, хөлдөөгч, нийт 47,843.0 мянган төгрөгийн хөрөнгийг Хонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн 19 тоот тогтоолыг үндэслэн эрхлэгчийн 2025 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/38 тоот тушаалаар үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, тайлант онд нийт 69,606.6 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,856,211.2 мянган төгрөг болж 4,524.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэг нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 556,887.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 123,016.3 мянган төгрөг, нийт 679,904.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 16,381.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 573,269.2 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 20,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 143,016.3 мянган төгрөг, нийт 716,285.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 8 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 370,725.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвийг 8,686.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 847,807.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 134,329.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 96,186.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 1,078,324.0 мянган төгрөг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 847,807.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 134,329.5 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 98,674.4 мянган төгрөг, нийт 1,080,811.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 979,701.1 мянган төгрөг буюу 90.9 хувьтай зарцуулж, 18,163.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, зарцуулаагүй үлдсэн 82,947.4 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

	71801	Сургуулийн өмнөх боловсрол	1,078,324.0	979,701.1	(98,622.9)	90.9
1	80111	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	134,329.5	116,166.5	(18,163.0)	86.5
2	80233	Хүүхэд хамгаалал	1,007.9	750.0	(257.9)	74.4
3	81605	Эрүүл мэндийг дэмжих	1,841.4	1,811.0	(30.4)	98.3
4	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	58,808.1	52,656.0	(6,152.1)	89.5
5	81816	Хүүдэд ээлтэй сургалтын орчин	2,559.5	2,557.3	(2.2)	99.9
6	81832	Нүүдэл бүлэг	22,631.4	22,005.9	(625.5)	-
7	81823	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,478.9	1,060.6	(418.3)	71.7
8	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх	854,493.9	781,520.4	(72,973.5)	91.5
9	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	1,173.4	1,173.4	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант онд 2 удаа зарласан боловч тендер харилцагч орж ирээгүй учир ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах

асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 14 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 756,450.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15,129.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 3,607.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	3,607.7	3	3,607.7	100
Нийт дүн	3	3,607.7	3	3,607.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 2,135.7 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд 737.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
2. Ашиглах жилийг оруулаагүйгээс 1,398.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцсон байна.

Энэ нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, “Ангилал”, “Толилуулга”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланг залруулав.

Мөн аудитаар илэрсэн 9,027.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,154.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 6,873.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, цаашид давтан гаргахгүй байх 2 зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо сул орон тооны цалингаас тооцолгүй 374.0 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Хөдөлмөрийн тухай 56 дугаар зүйлийн 56.2-т “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант оны 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг нэмэгдсэн цалингаас тооцсоноос 11 ажилтанд 1,776.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Цэцэрлэгийн эрхлэгч болон байгууллагын санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 6,873.1 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн

тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1 Тус сургууль нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2 Бараа материалын тайлан, орлого зарлагыг түүвэрлэн шалгахад бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" 10 дугаар хавсралт "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө" заалтуудыг зөрчсөн ба "Үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх. Бараа материалыг зөв ангилан бүртгэж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс	Зөвлөмж

			Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан				Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд дутуу илэрхийлсэн	1	737.4	1	737.4			1	737.4				
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу бодуулсан.	1	1,398.3			1	1,398.3	1	1,398.3				
Дүн	2	2,135.7	1	737.4	1	1,398.3	2	2,135.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил хавсарсны нэмэгдлийг буруу бодож олгосон.	1	374.0	1	374.0								
Үр дүнгийн урамшуулал илүү олгосон.	1	1,776.0	1	1,776.0								
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон.	1	6,873.1			1	6,873.1						
Бараа материалын ангилал буруу бүртгэсэн	1						1					
Ахмадын сан байгуулаагүй	1						1					
	5	9,027.1	2	2,154.0	1	6,873.1	2					

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Хонгор сумын 16 дугаар сургууль

Аудитын код: ДАА-2025/62/НА-СТА-ТШЗ

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит

Тайланг хугацаа: 2024.01.01-2024.12.31

Эрсдэлтэй АГАДУТ-н түвшинд хэрэгжүүлэх түүврийн сорилын үр дүнг үнэлж шийдвэрлэх

№	Нөлөөлж буй АГАДУТ	АГАДУТ-ийн дэд анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Стандартын заалт	Шалгуур үзүүлэлт		Алдаа, зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл	
								Хууль тогтоомжийн заалт	Хууль тогтоомжийн заалт						
А	1	Ажил гүйлгээний анги	Тайланг оны 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг нэмэгдсэн цалингаас тооцсон, эзлэгийн амралттай болон сахилгын шийтгэлтэй ажилтан нарт үр дүнгийн урамшуулал бодож олгосон.	1,776,000.00	Шинж чанарын хувьд материаллаг	Тийм	УСНББОУС 1	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дахь бүлэг, 3 дугаар хавсралтын 2.7	Зөрчил	Төлбөрийн акт тогтоох	10	11	12	13	
2	Ажил гүйлгээний анги	Урсгал зардал	Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгоходоо сул орон тооны батлагдсан үндсэн цалингаас ажил хавсарсны нэмэгдлийг тооцолгүй илүү олгосон.	374,000.00	Шинж чанарын хувьд материаллаг	Тийм	УСНББОУС 1	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай 56 дугаар зүйлийн 56.1, 56.2.	Зөрчил	Төлбөрийн акт тогтоох	10				
3	Ажил гүйлгээний анги	Урсгал зардал	Цэцэрлэгийн эрхлэгч болон санхүүгийн 2 ажилтан үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгосон.	6,873,100.00	Шинж чанарын хувьд материаллаг	Тийм	УСНББОУС 1	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2	Зөрчил	Албан шаардлага					
4	Ажил гүйлгээний анги	Бараа материал	Бараа материалын дэлгэрэнгүй тайланг дансны ангиллыг буруу бүртгэсэн.		Шинж чанарын хувьд материаллаг	Үгүй	УСНББОУС1, УСНББОУС12	Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8 дугаар бүлэг	Зөрчил	Зөвлөмж өгөх					
5	Ажил гүйлгээний анги	Хууль тогтоомж	Ахмадын сан байгуулаагүй.		Шинж чанарын хувьд материаллаг	Үгүй	УСНББОУС1, УСНББОУС2	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт	Зөрчил	Зөвлөмж өгөх					
Дүн															
				9,023,100.00											

Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой биш эрсдэлүүдэд хэрэгжүүлэх горим, сорилын үр дүнг үнэлж шийдвэрлэх

№	Тодорхойлсон эрсдэл	Үр дагавар	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Стандартын заалт	Шалгуур үзүүлэлт		Алдаа, зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
								Хууль тогтоомжийн заалт	Хууль тогтоомжийн заалт					
А	1	Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүргэх	Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйцэтгэлийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн.	737,440.84	Шинж чанарын хувьд материаллаг	Үгүй	УСНББОУС 1	Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 10 дугаар бүлэг	Алдаа	Залруулах	10	11	12	13

Санхүүгийн тайлан тооцоллын хувьд алдаатай, харилцан уялдаагүй байх	Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүргэх	Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу бодуулсан.	Шинж чанарын хувьд материаллаг	Үгүй	УСНББОУС 1	Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нэгтгэл бодох бүртгэлийн журам"-ын 10 дугаар бүлэг	Алдаа	Заглуулах	
2			1,398,276.00						
Дүн			2,135,720.84						
Бусад хуулийн хэрэгжилтийг үнэлэх эрсдэлүүдэд хэрэгжүүлэх горим, сорилын үр дүнг үнэлэх									
1	Ажил гүйлгээний анги	Хууль тогтоомж	Ахмадын сан байгуулаагүй.	Үгүй	УСНББОУС1; УСНББОУС2	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт	Зөрчил	Зөвлөмж өгөх	
Дүн									
Нийт дүн			11,162,820.8						

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн:

Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Т.Оюунчимэг

Огноо:

Нягтлан бодогч..... Г.Галсанцэрэн

Огноо:

Зөвшөөрөөгүй бол шалтгааныг бичнэ

Асуудлын бүртгэл хөтөлсөн: Аудитор

Огноо: 2025.02.20

Анхан шатны хяналт хийсэн: Аудитын менежер

Огноо:

Хоёр дахь шатны хяналт хийсэн: Газрын дарга, тэргүүлэх аудитор

Огноо:

Ш.Мөнхбаяр